

Аймгийн Засаг даргын 2022, оны 12. дугаар
сарын 22-ны өдрийн 17:09 дүгээр захирамжийн
хоёрдугаар хавсралт



“АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА” ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймгийн “Хөдөлмөрийн аварга”-ын тэмдэг, үнэмлэх нь аймгийн Засаг даргын нэрэмжит шагналын нэг мөн.

1.2. Аймгийн “Хөдөлмөрийн аварга” шагналын зорилго нь Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, улс, аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд өөрийн эзэмшсэн мэргэжил, ур чадвараараа манлайлж, олимп, тив дэлхий, улс, аймгийн чанартай уралдаан тэмцээн, соёл урлагийн арга хэмжээнд тэргүүн байр эзэлсэн зэрэг хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан хавсралтад дурдсан албан хаагч, ажилтан, иргэдийг алдаршуулахад оршино.

1.3. Аймгийн “Хөдөлмөрийн аварга”-аар шагнах хүнийг Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, хэрэгжүүлэгч агентлаг, албан байгууллага, аж ахуйн нэгжийн тодорхойлолт, саналыг үндэслэн хавсралтад заасан хязгаарт багтаан Засаг дарга жил бүрийн Сар шинийн баярын өмнө нэг удаа шалгаруулна.

Хоёр. Шагналд тодорхойлох, шалгаруулах журам

2.1. Аймгийн “Хөдөлмөрийн аварга”-аар тодорхойлогдсон ажилтан, иргэн нь эрхэлж буй салбартаа онцгой амжилт гаргасан, салбарын ажил хөдөлмөр, үйлчилгээний тоо, чанар нь сүүлийн 3 жилд өссөн үзүүлэлттэй, нийгмийн хариуцлагын хүрээнд санал санаачилгатай ажилласан байх, сум, орон нутаг, байгууллага хамт олон, иргэдийн дунд нэр хүндтэй, манлайлагч, ёс зүй, сахилгын зөрчилгүй, бусдыг үлгэрлэн манлайлдаг зэрэг байдлыг хэлэлцэнэ.

2.2. Аймгийн “Хөдөлмөрийн аварга”-аар тодорхойлогдсон ажилтан, иргэний аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжил, тухайн салбар, байгууллагын үйл ажиллагаанд оруулсан хувь нэмэр, ажлын үр дүнгийн үзүүлэлтийг 3-аас доошгүй жилээр гаргаж, тодорхойлолтод тоо баримт, үр дүнг тооцон тусгасан байна.

2.3. Аймгийн “Хөдөлмөрийн аварга”-аар тодорхойлогдсон ажилтан, иргэн нь байгууллага, сумын “Хөдөлмөрийн аварга”-аар шалгарсан байх ба системийн дээд

2.

байгууллагаас мэргэшил, ур чадварыг нь үнэлж, шагнаж урамшуулсан байх шаардлагыг хангасан байна.

2.4.Аймгийн “Хөдөлмөрийн аварга”-аар тодорхойлогдсон ажилтан, иргэний материалыг сум, байгууллага нь жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяалах бодлогын хэлтэст ирүүлэх ба бодлогын хэлтэс нь ирүүлсэн материалыг журмын шаардлага хангаж буй эсэхийг хурлаараа хэлэлцэн болзол хангасан ажилтан, иргэний холбогдох материалыг хурлын тэмдэглэлээр баталгаажуулан жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлсэн байна.

2.5.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс нь бодлогын хэлтсүүдээс ирүүлсэн салбар бүрийн нэр дэвшигчийн тодорхойлолт, холбогдох материалыг жил бүрийн 01 дүгээр сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын дэргэдэх Удирдлагын багийн хуралд хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

2.6.Аймгийн “Хөдөлмөрийн аварга”-аар шалгарсан нэр дэвшигчийг “Аймгийн хөдөлмөрийн аварга”-ын энгэрийн тэмдэг, үнэмлэх, дагалдах мөнгөн шагнал 500000 /таван зуун мянга/ төгрөгөөр шагнаж урамшуулна.

2.7.Аймгийн “Хөдөлмөрийн аварга”-ын шагналыг жил бүрийн Сар шинийн баярын өмнө аймгийн Засаг дарга түүний ажлын алба гардуулна.

2.8.”Аймгийн хөдөлмөрийн аварга”-ын шагналыг тухайн хүнд дахин олгохгүй.

Гурав.Шагналд нэр дэвшигчийн тодорхойлолт материалыг хүлээн авахад тавигдах шаардлага

3.1.Аймгийн “Хөдөлмөрийн аварга”–аар тодорхойлогдсон нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолт, анкет /хавсралт загвараар 3x4 хэмжээний зураг/ хамт олны хурлын тэмдэглэл, байгууллагаас шагналд уламжилсан албан бичиг зэргийн бүрдлийг хангасан материалыг ирүүлсэн байна.

3.2.Журамд заасан холбогдох материал дутуу тохиолдолд сайжруулалт хийлгэхээр тодорхой хугацаа заан буцаах буюу дахин шаардлага хангаагүй мөн хугацаа хожимдсон бол материалыг шийдвэрлүүлэхгүй буцаах эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс нь эдэлнэ.

3.

ШАГНУУЛАХ ХҮНИЙ АНКЕТ

1	Эцэг /эх-ийн нэр, өөрийн нэр	
2	Регистрийн дугаар	
3	Хүйс	
4	Боловсрол	
5	Мэргэжил	
6	Үндсэн захиргаа	
7	Ажлын туршлага	
8	Бусад ямар шагналаар хэзээ шагнагдсан	
9	Шагнуулах гэж буй үндэслэл	
10	Тодорхойлсон шагнал	

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН

.....

.....

.....

/ Албан тушаал/ /гарын үсэг/ /албан тушаалтны Нэр/

Аймгийн Засаг даргын 8/200.. оны 12 дугаар
сарын 22-ны өдрийн 11:16:4 дүгээр захирамжийн
гуравдугаар хавсралт



БАЯНХОНГОР АЙМГИЙН “ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА” –ААР
ШАЛГАРУУЛАХ ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР

1. Төрийн албан хаагч	1
2. Боловсролын салбарын ажилтан	1
3. Эрүүл мэндийн салбарын ажилтан	1
4. Хууль, хяналтын байгууллагын ажилтан	1
5. Төрийн цэргийн байгууллагын ажилтан	1
6. Биеийн тамир, спортын салбарын ажилтан	1
7. Соёлын салбарын ажилтан	1
8. Аж үйлдвэрийн салбарын ажилтан	1
9. Дэд бүтэц, барилгын салбарын	1
10. Авто, тээврийн салбарын ажилтан	1
11. Мэдээлэл, холбооны салбарын ажилтан	1
12. Үйлчилгээний ажилчин	5 хуртэл
13. Санхүү, эдийн засгийн салбарын ажилтан	1
14. Хөдөө аж ахуйн салбарын ажилтан	1
15. Байгаль орчин, цаг уур, уул уурхайн салбарын ажилтан	1
16. Нийгмийн хамгааллын салбарын ажилтан	1
17. Иргэний нийгмийн байгууллагын ажилтан	1
18. Хөдөлмөр, жижиг дунд үйлдвэрлэл худалдаа үйлчилгээ	1
19. Албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал, эрхлэгч-1	

Тайлбар :

а/ Төрийн албан хаагч : -Нутгийн өөрөө удирдах байгууллага
-Төрийн захиргааны албан хаагч

б/Хөдөлмөр, жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээнд: Татварын албан
бүртгэлтэй худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчид;

в/Иргэний нийгмийн байгууллагад: Олон улсын байгууллага болон төрийн
бус байгууллагууд;

г/Төрийн цэргийн байгууллагад: Онцгой байдлын газар, Зэвсэгт хүчний анги,
Тагнуулын газар

2.

д/Хууль, хяналтын байгууллагад: Цагдаагийн газар, Шүүхийн Тамгын газар, Прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Шүүхийн шинжилгээний алба.

_____oOo_____